



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 8 сарын 29 өдөр

Дугаар 276

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард даатгал” ХХК нь нээлттэй хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан тус компанийн нэг бүр нь 200 /хоёр зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 25,000,000 /хорин таван сая/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Ард даатгал” ХХК-ийн нэг бүр нь 200 /хоёр зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 17,500,000 /арван долоон сая таван зуун мянга/ ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэхүү тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 7,500,000 /долоон сая таван зуун мянга/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 700 /долоон зуу/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Ард даатгал” ХХК /Г.Цогбадрах/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 3-д заасан нийтэд санал болгон худалдаалах хувьцааг 100 /нэг зуу/ хувь зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохыг “Ард даатгал” ХХК /Г.Цогбадрах/-д мэдэгдсүгэй.

5. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

6. Энэ тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д үүрэг болгосугай.


7. Энэ тогтоолын 4-т заасан нийтэд санал болгон худалдах хувьцааны 100 /нэг зуу/ хувийг анхдагч зах зээлд арилжаалж, шаардлагатай хөрөнгийг татан төвлөрүүлж чадаагүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Бидисек ҮЦК” ХК /Д.Даянбилгүүн/-д анхааруулсугай.

8. “Ард даатгал” ХХК нь нээлттэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Ард даатгал” ХХК /Г.Цогбадрах/-д үүрэг болгосугай.

9. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Бидисек ҮЦК” ХХК /Д.Даянбилгүүн/, “Өмгөөллийн И Эл Си” ХХН /Б.Баяр/, “БДО Аудит” ХХК /Г.Баянмөнх/, “Далайван Аудит” ХХК /Ц.Жигдэн/-д тус тус анхааруулсугай.


10. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 3 дугаар сарын 29-ний
өдрийн 2% дугаар тогтоолын хавсралт



№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны тоо ширхэг	Хувьцааны эзэмшлийн хувь
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	16,679,250	66.72%
2	“Энержи интернэйшнл капитал” ХХК	820,750	3.28%
	Нийт дун	17,500,000	70.00%